

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХҮН АМЫН ЭРҮҮЛ МЭНД, ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

/2025 оны 1 сарын байдлаар/

№	Үзүүлэлт	БОЭТ	Сумдын эмнэлэг	Өрхийн эмнэлэг	Хувийн эмнэлэг	Цэргийн анги	Нийт дүн
1	Нийт үзлэг	16693	8682	8198	5347		38920
2	Урьдчилан сэргийлэх үзлэг	2144	1816	3197	525		7682
3	Идэвхтэй хяналтын үзлэг	3066	600	957	179		4802
4	Бүртгэгдэж эмчлэгдсэн өвчлөл	5576	2069	1598	1187		10430
5	Нийт төрөлт	75	14				89
6	Хэвтэн эмчлүүлэгчид	858	705		322		1885
7	Нас баралт	7	11	10			28

№	Үзүүлэлт	2024.1	2025.1	Өөрчлөлт
1	Нийт үзлэг	36316	38920	2604
2	Урьдчилан сэргийлэх үзлэг	9425	7682	-1743
3	Идэвхтэй хяналтын үзлэг	3340	4802	1462
4	Бүртгэгдэж эмчлэгдсэн өвчлөл	9177	10430	1253
5	Нийт төрөлт	103	89	-14
6	Гэрийн төрөлт	0	0	0
7	Хэвтэн эмчлүүлэгчид	1788	1885	97
8	Нас баралт	30	28	-2
9	0-1 насны эндэгдэл	4	2	-2
10	1-5 насны эндэгдэл	0	1	1
11	Хурц халдварт өвчин	88	36	-52

Үзүүлэлт	хэмжих нэгж	2024.1 сар	2025.1 сар	өөрчлөлт
Нялхасын эндэгдэл	1000 амьд төрөлтөд	38.8	2.2	-36,6
Үр хөндөлт	1000 амьд төрөлтөд	582.5	483.1	-99.4
Үүнээс охидын	хувь	8.3	1,1	-7,2
Хурц халдварт өвчин	10000 хүн амд	11.6	4,7	-6.9
БЗДХ	10000 хүн амд	4.6	6.2	1.6
Үүнээс өсвөр үе	хувь	22.8	22.5	0.3
Хүүхдийн хяналт /0-1 нас/	хувь	76.5	73,2	-3,3
Хүүхдийн хяналт /1-5 нас/	хувь	26.5	29,1	2,6

I.ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

- Улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд нийт 38920 хүнд үзлэг шинжилгээ хийсний 32.1%-д нь урьдчилан сэргийлэх болон идэвхтэй хяналт тандалтын үзлэг хийгдсэн байна.
- Ортой эмнэлгүүдэд нийт 1885 хүнийг 12727 ор хоногоор хэвтүүлэн эмчилсэн нь нэг хүн дунджаар 6.7 хоног хэвтэн эмчлүүлсэн байна.
- Түргэн тусламжийн 963 дуудлагад явж үйлчилсний 145 (15.1%) нь алсын дуудлага, 80 (8.3%) нь осол гэмтлийн яаралтай дуудлага байсан байна.
- Нийт эмийн сангууд 20595 жор хүлээн авч, 1 тэрбум 5 сая гаруй төгрөгний эм бараа борлуулалт хийсэн байна.
- ЭЭСангуудад нийт 1871 жор ирсний 26.2% (490) нь ЭМДаатгалын, 0.3% (6) мансууруулах сэтгэц нөлөөт эмийн, 73.5% (1375) нь энгийн эмийн жор байсан байна. Зайлшгүй шаардлагатай эмийн хангалт дунджаар 37.9% байна.

II.БҮРТГЭГДСЭН ӨВЧЛӨЛ, ЭНДЭГДЭЛ

1. 1 сарын байдлаар 10430 халдварт бус өвчлөл шинээр бүртгэгдэж эмчлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 1253 тохиолдлоор өссөн байна. Нийт өвчлөлийн 67% нь шинэ өвчлөл байна.
2. **Үүнээс тэргүүлэх 5 өвчлөл нь:**
 1. Амьсгалын тогтолцооны өвчин-3564
 - 2.Хоол шингээх эрхтний өвчин-1315
 3. Шээс бэлэгсийн тогтолцооны өвчин -1063
 4. Цусны эргэлтийн тогтолцооны өвчин -733
 5. Мэдрэлийн тогтолцооны өвчин-456
3. 1 сарын байдлаар 156 хүн осол гэмтэлд өртсөний улмаас тусламж авсан ба өвчлөл өнгөрсөн оноос 25 тохиолдолоор буурсан байна.
4. Оны гарсаар 28 хүн нас барсан ба нийт нас барсан хүний 14,3% нь хорт хавдраар,3.6% нь зүрхний шигдээс, тархинд цус харвалт зэрэг сэргийлж болох эндэгдэлээр нас барсан байна. Нийт нас баралтын 10 нь эмнэлэгт, бусад нь гэртээ хээр гадаа нас барсан байна.
5. БОЭТөвд 7 эндэгдэл тохиолдож 4 задлан шинжилгээнд хамруулсан байна.
6. **Нас баралтын шалтгаан:**
 - 1.Цусны эргэлтийн тогтолцооны өвчин-8
 - 2 Хорт хавдраар-4
 3. Осол гэмтлээр-3
 4. Амьсгалын тогтолцооны өвчин-4
 5. Хоол шингээх эрхтний өвчин-2
 - 6 .Чихрийн шижин-1
 7. Архины хордлого-2
 - 8.Бөөрний архаг дутагдал-1
 9. Перинаталь үеийн эмгэг-2
 10. R54- хөгшрөл-1

III.ЭХ, ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД

- Нийт 89 эх төрж 91 хүүхэд мэндэлсэн нь өнгөрсөн онтой харьцуулахад 14 төрөлтөөр хүн амын төрөлт буурсан байна. Нийт төрсөн хүүхдийн хүйсийн харьцаа 1,1:1 байгаа ба эмэгтэй хүйс давамгайлж байна.
- Нийт төрөлтийн 8.9% (8) дутуу төрөлт эзэлж байна.
- Нийт төрөлтийн 1 (1,1%) охидын төрөлт эзэлж байгаа ба өнгөрсөн оны мөн үеэс (2.7%)3-р буурсан үзүүлэлттэй байна.(шб-1).
- 1 сарын байдлаар 43 эх үр хөндүүлж 1000 амьд төрөлтөд 483,1 байгаа нь өнгөрсөн оноос 99,4-р буурсан үзүүлэлт байна.
- 136 жирэмсэн эх хяналтанд шинээр орсны эхний 3 сартайд 127 (93,4%) , 4-6 сартайд 9 (6,6%) , хожуу 1 (0.7%) хяналтад орсон байна.
- Нялхсын эндэгдлийн 2 тохиолдол бүртгэгдсэн байна. 1-5 настай хүүхдийн эндэгдэл -1 бүртгэгдсэн байна. Эндэгдэлийн шалтгаан нь осол гэмтэл, нярайн амьсгалын гачаалын шалтгаантай байна.
- 1 сарын байдлаар 2828 хүүхдийг идэвхтэй хянаж, хооллолт өсөлт хөгжилтийн байдлыг үнэлэн зөвлөгөө дэмжлэг үзүүлсэн нь хяналтад хамрагдвал зохих хүүхдийн 37,0% эзэлж байна. Хяналтанд хамрагдсан хүүхдүүдээс 19 хүүхэд жингийн алдагдалтай байгаа нь нийт хүүхдийн 0,7%-г эзэлж байгаа ба 15 хүүхэд туранхай, тураалтай-4 хүүхэд өсөлт хоцрогдолтой байна.
- 0-1 насны хүүхдийн хяналт 73,2%, 1-5 хүртэлх насны хүүхдийн хяналт 29,1%-тай байна.

IV. ХАЛДВАРТ ӨВЧИН

- Он гараад 76 халдварт өвчин бүртгэж эмчилсэн нь өнгөрсөн оноос 47 тохиолдлоор буурсан байна. Нийт халдварт өвчний 52,6%-г БЗДХ, 38,1%-г салхинцэцэг, 1,3%-г цусан суулга, 2,6%-г гар хөл амны өвчин, 2,6%-г ёлом, 2.6%-г гепатит, 1,3%-г улаан эсэргэнэ зэрэг өвчнүүд тус тус эзэлж байна.
- БЗДХ-н 7,5% нь жирэмсний үзлэгээс, 7,5% нь урьдчилан сэргийлэх үзлэгээр, 82,5% нь өвчний учир амбулатороор, 10% нь тандалтын үзлэгээс илэрсэн байна.

1 САРД АНХААРАЛ ТАТСАН ҮЗҮҮЛЭЛТҮҮД:

1. Төрөлт өнгөрсөн оны мөн үеэс 14 тохиолдлоор буурсан байна.
2. 0-1 хүртэлх насны хүүхдийн хяналтын хувь өнгөрсөн оны мөн үеэс 3.3%-р буурсан байна.
3. БЗДХ өнгөрсөн оны мөн үеэс 1.6%-р нэмэгдсэн байна .

Мэдээлэл бэлтгэсэн: ЭМГ-н статистикч О.Хандармаа, Ш.Нарандалай

2025 оны 2 сарын 5